



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2026/07/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2026 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Батсайхан

Утас: 70592225

Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Угтахбаяр

Утас: 70593113

Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	Error! Bookmark not defined.
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	Error! Bookmark not defined.
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	Error! Bookmark not defined.
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	Error! Bookmark not defined.
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	Error! Bookmark not defined.
4. АУДИТЫН ТАЙЛАН	Error! Bookmark not defined.
4.1 Ерөнхий зүйл.....	Error! Bookmark not defined.
4.2 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	Error! Bookmark not defined.
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
4.5.1 Завсрын аудитын талаар.....	Error! Bookmark not defined.
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	Error! Bookmark not defined.
5. Аудитын илрүүлэлт	6
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1.Аудитын санал дүгнэлт

	
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР	
<small>Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208, 70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn</small>	
_____	_____
2026.03.27	№ 93
_____	_____
танай	-ны № _____ -т
Оөрчлөлтгүй дүгнэлт	

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэрэн сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2025 оны 01 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалин нэмсэнтэй холбоотой төсөвт байгууллагуудын цалингийн зардал өмнөх оноос 123.7 сая төгрөгөөр өссөн байна.

Дэрэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Сумын 2025 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 36 дугаар тогтоолоор тайлант онд 513.1 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 751.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 143.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад 2025 оны сүүлээр төсвийн орлогын бүрдэлтэй уялдуулан төсвийг хэмнэлттэй хуваарилж, зарцуулах, төсвийн сахилга батыг чангатгах, төрийн санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор төрийн сангийн дансны гүйлгээний

4826050314

эрхийг хаасантай холбоотой төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны зардалтай холбоотой өр төлбөр өсч, өмнөх оноос 138.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилт, 128 арга хэмжээг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 86.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	1.1 ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,147,364.2	1,257,956.3
31	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	724,499.7	966,066.5
33	1.1.3 АВЛАГА	164,218.1	94,913.3
34	1.1.4 УРЬДЧИЛГАА	55.0	-
35	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	240,091.4	186,976.5
360	1.1.7 БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	18,500.0	10,000.0
2	1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,200,120.0	1,228,304.7
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,200,120.0	1,228,304.7
3	1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	2,347,484.2	2,486,261.0
4	2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР	14,625.7	25,476.0
41	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,625.7	25,476.0
5	2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,332,858.4	2,460,785.1
51	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	2,332,858.4	2,460,785.1
6	2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	2,347,484.2	2,486,261.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	2,447,563.5	2,299,615.7
11	1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	639,677.2	716,991.0
110	1.1.1.03.1 Орлогын албан татвар	378,084.3	374,608.3
1100	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	378,084.3	374,608.3
113	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	52,266.6	113,135.9
118	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	209,326.3	229,246.7
1180	1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,557.5	18,487.2
1181	1.1.1.03.8.02 Газрын төлбөр	19,728.9	21,889.5
1182	1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	170,040.0	188,870.0
12	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	643,954.4	1,582,624.7
120	1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	643,954.4	251,739.8
122	1.1.1.04.3 Тусламжийн орлого	1,163,931.9	971,283.5
1221	1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	1,163,931.9	971,283.5
123	1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	359,601.4
II	1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,399,146.0	1,663,351.1
21	1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,399,146.0	1,663,351.1
210	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,342,116.0	1,654,801.1
2101	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	521,375.4	645,144.8
2102	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,549.4	75,705.8
2103	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	254,604.3	300,129.9
2104	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	77,074.2	91,170.5
2106	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	49,934.1	83,007.1
2107	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	20,154.0	16,800.0
2108	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,327.3	31,345.0
2109	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	334,097.3	411,498.1
213	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,030.1	8,550.0
2132	1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	52,807.9	8,550.0
2134	1.1.2.01.4.04 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,222.2	-
III	1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,048,417.4	636,264.6
V	1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	387,598.5	503,296.0
VII	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(387,598.5)	(503,296.0)
VI	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	660,818.9	132,968.5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,427.2	99,403.9	1,157,208.4	1,672,039.5
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	415,427.2	99,403.9	1,157,208.4	1,672,039.5
9	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	660,818.9	660,818.9
10	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	415,427.2	99,403.9	1,818,027.3	2,332,858.4
11	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	415,427.2	99,403.9	1,818,027.3	2,332,858.4
12	1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(5,041.9)	(5,041.9)
13	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	415,427.2	99,403.9	1,812,985.4	2,327,816.5
19	1.7 Тайлант үеийн үр дүн	-	-	132,968.5	132,968.5
20	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	415,427.2	99,403.9	1,945,954.0	2,460,785.1

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,938,768.9	2,206,581.5
11	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	639,677.2	716,991.0
110	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	378,084.3	374,608.3
1100	1.1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	378,084.3	374,608.3
113	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	52,266.6	113,135.9
118	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	209,326.3	229,246.7
1180	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	19,557.5	18,487.2
1181	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	19,728.9	21,889.5
1182	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	170,040.0	188,870.0
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	135,159.8	1,489,590.5
120	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	135,159.8	130,960.2
122	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	-	999,028.9
1221	1.1.1.1.04.3.01 Хандив тусламж /дотоод/	-	999,028.9
123	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	359,601.4
13	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,163,931.9	-
1310	1.1.1.1.05.1 Улсын төвлөрсөн төсвөөс	298,557.8	-
1311	1.1.1.1.05.2 Нэмэлт санхүүжилтийн орлого	75,557.8	-
1320	1.1.1.1.05.3 Орон нутгийн төсвөөс санхүүжих	789,816.3	-
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,272,380.3	1,472,083.1
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,272,380.3	1,472,083.1
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,215,350.3	1,439,512.5
2101	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	515,435.4	656,126.6
2102	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,549.4	75,705.8
2103	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	254,659.3	300,074.9
2104	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	51,524.9	25,259.3
2106	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	44,003.3	80,735.4
2107	1.1.1.2.01.1.07 Томилт, зочны зардал	19,814.0	12,240.0
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,327.3	31,345.0
2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	245,036.7	258,025.6
213	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,030.1	32,570.5
2131	1.1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	24,020.5
21311	1.1.1.2.01.4.01.01 Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	24,020.5
2132	1.1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	52,807.9	8,550.0

2134	1.1.1.2.01.4.04 Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	4,222.2	-
III	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	666,388.6	734,498.4
V	1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	342,393.7	492,931.6
22	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	342,393.7	492,931.6
2200	1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	342,393.7	492,931.6
VI	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(342,393.7)	(492,931.6)
VIII	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	323,994.8	241,566.9
101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	400,504.8	724,499.7
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	724,499.7	966,066.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,601,516.0	2,125,862.1
11	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	513,060.6	716,991.0
12	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,088,455.4	1,408,871.1
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,601,516.0	1,875,136.6
21	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,852,516.4	1,382,205.0
210	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,832,266.4	1,373,655.0
2101	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	699,326.2	656,126.6
2102	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,089.7	75,705.8
2103	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	359,483.3	299,096.1
2104	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	40,512.5	24,499.3
2106	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	84,289.2	80,735.4
2107	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	15,520.0	12,240.0
2108	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	49,762.6	30,271.3
2109	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	496,255.9	194,980.6
213	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,250.0	8,550.0
2131	1.1.1.2.01.4.01 Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
2132	1.1.1.2.01.4.02 Бусад урсгал шилжүүлэг	20,250.0	8,550.0
22	1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	551,536.5	492,931.6
101	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	711,465.4
20	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	962,191.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	80,719.4
12	1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,719.4
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	80,719.4
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	80,719.4
II	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	56,698.9
21	1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ	56,698.9
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	56,698.9
2103	1.1.1.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	978.8
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	760.0
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,073.7
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	53,886.4
4	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,020.5

3. Аудитын илрүүлэлт

3.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дэрэн сумын Засаг даргын 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй. Харин Байгаль хамгаалах сангийн санхүүгийн тайланд насжилт өндөртэй 1,500.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй зөрчил илэрснийг албан шаардлага хүргүүлээ.

3.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 4 сан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нуггийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 230,606.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 59,152.8 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 169,327.8 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага, 2,126.2 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 74.3 хувийг залруулагдаагүй, 25.7 хувийг залруулсан алдаа эзэлж байна.

Нийт 171,454.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчлийн 78.1 хувь буюу 133,892.8 мянган төгрөг нь нийцлийн аудитын асуудал, үлдсэн 21.9 хувь буюу 37,561.2 мянган төгрөг нь санхүүгийн тайлангийн аудитын зөрчил байна. Завсрын аудитаар хүргүүлсэн авлага барагдуулах 21,550.0 мянган төгрөгийн албан шаардлагыг жилийн эцсийн санхүүгийн тайланд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Харин санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 16,011.2 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 6,984.9 мянган төгрөгөөр бага тул “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	2,126.2					1	2,126.2				
Засаг даргын Тамгын газар	-	-										
Хоршоо хөгжүүлэх сан	-	-										
Орон нутгийн хөгжлийн сан	1	131,766.6			1	131,766.6						
Мал хамгаалах сан	-	-										
Нийт дүн	2	133,892.8	-	-	1	131,766.6	1	2,126.2	-	-	-	-